



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СӨНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№101 /101/

2021.07.29

ҮЙЛ ЯВДАЛ

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэг аймаг, орон нутагт үргэлжилж байна.

Батлан хамгаалахын сайдын баталсан журмын дагуу ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын офицер, ахлагч нарын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшнийг нэгдсэн журмаар шалгаж, 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Төв аймагт байрлах Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад түвшин тогтоох үзлэгийг амжилттай зохион байгууллаа.

Харин аймаг, орон нутагт байрлах Зэвсэгт хүчний анги, салбаруудын түвшин тогтоох үзлэгийг 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрөөс Зэвсэгт хүчний 330 дугаар ангиас эхэлсэн.

Одоогийн байдлаар Зэвсэгт хүчний 28 нэгтгэл, анги, байгууллагууд, Төв, Дархан-Уул, Орхон, Булган, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нар бүрэн хамрагдаад байна.

Энд тодруулахад, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр БХЯ-ны харьяа байгууллагууд болон нийслэл, аймгийн Цэргийн штабын бие бүрэлдэхүүнийг нэг ажлын хэсгээр шалгаж, түвшнийг тогтоохоор шийдвэрлэсэн нь үзлэгийн ач холбогдол, хамрах хүрээг улам нэмэгдүүлсэн юм.

Энэхүү үзлэг нь Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшнийг тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой явагдаж байна.

Аймаг, орон нутагт байрлах буй Зэвсэгт хүчний анги, салбарууд энэхүү үзлэгт өндөр ач холбогдол өгч, бие бүрэлдэхүүнээ бэлтгэн, идэвх, санаачилгатай хамрагдаж байгааг үзлэгийн дүнгээс харж болно.

Үзлэгт офицер, ахлагч нарыг бүрэн хамруулан түвшнийг нь бодитоор тогтоох зорилгоор алслагдсан тусгай салбаруудад хүрч, хүн нэг бүртэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, үнэлэлт, дүгнэлт өгч байгаагаараа онцлогтой болж байна. Мөн анги, байгууллагын үйл ажиллагааг үнэлж, дүгнэхээс илүүтэй хувь хүнийг үнэлж, дүгнэн, ямар түвшинд байгаа болон алдаа, дутагдал, өөрийгөө хөгжүүлэхэд анхаарах чиглэлийг тайлбарлан таниулж байгаагаараа онцлогтой.

Түүнчлэн офицер, ахлагч нарын албандаа хандах хандлагыг өөрчлөх, үүрэг, хариуцлагыг нь ухамсарлуулах, цэргийн алба хаагчдад тавигдаж буй шалгуур, шаардлагыг таниулах ажлыг харилцан ярилцлага, дүн гаргах явцад хэрэгжүүлж байна.

Бие бүрэлдэхүүнийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулан эмх журамтай, сахилга баттай хамруулах нь цаг хугацааг хэмнэж, чанартай үнэлэлт, дүгнэлт өгөх боломжийг бүрдүүлдэг юм. Тухайлбал, Зэвсэгт хүчний 186 дугаар анги биеийн тамирын шалгалт авах байр, талбайгаа сайтар бэлтгэсэн, Зэвсэгт хүчний 330 дугаар анги ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажиллах орчин нөхцөлийг нь сайн бүрдүүлсэн, Зэвсэгт хүчний 110 дугаар анги бие бүрэлдэхүүнээ сахилга, зохион байгуулалт сайтай хамруулсан зэрэг сайн талуудыг нь онцлох учиртай.

Мөн Хөвсгөл аймагт байрлах Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 321 дүгээр тусгай ротын захирагч хошууч Р.Цэрэндорж түвшин тогтоох үзлэгт офицер, ахлагч нараа сайн бэлтгэж, бие бялдрын түвшин тогтоох шалгалтад амжилттай шалгагдсаныг нь сайшаан тэмдэглэе.

Түвшин тогтоох үзлэгийн цар хүрээ нэмэгдэж, ангиудаас гадна алслагдмал тусгай салбаруудыг үзлэгт бүрэн хамруулах, тогтоосон хугацаанд нь үзлэгийг дуусгах шаардлагын үүднээс амралтын өдөр, ажлын цагаар хязгаарлахгүйгээр илүү цагаар ажиллуулж байгаа юм.

Цаашид офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэг баруун аймгуудад байрлах Зэвсэгт хүчний анги, салбаруудад үргэлжилнэ.

Хурандаа Т.МӨНХСАРУУЛ



ШИЙДВЭРТЭЙ ДЭМЖЛЭГ АЖИЛЛАГААНЫ ХОЙД БҮСИЙН КОМАНДЛАГЧААС ЗАХИДАЛ ИРЛЭЭ



Эрхэм дэслэгч генерал аа, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй НАТО-гийн цэргийн "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаа дуусгавар болох цаг хугацаа дөхсөн энэ үед Афганистан Улсын хойд бүсэд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багтай хамтран үүрэг гүйцэтгэсэнд туйлын их талархаж байгаагаар танд мэдэгдэж буйг минь хүлээн авна уу.

Миний бие Афганистан дахь "Сургах-зөвлөх-туслах командлал буюу ТААС"-ыг 2020 оны 08 дугаар сараас хойш удирдаж байна. Уг командлалыг удирдсан цагаас хойш Монгол цэргүүдийг бодитоор нь, дэргэдээс нь харах боломж олдсон бөгөөд таны цэргүүдийн мэргэжлийн ур чадвар, сахилга батыг бахархан хүндэтгэж байна.

Танай цэргийн алба хаагчид Мармал баазын фронтын шугамд ажиллаж, үндсэн шалган нэвтрүүлэх хаалгыг хамгаалах үүрэг хүлээн, хариуцлагыг бүрэн ухамсарлан алба хааж байсан. Таны цэргүүд манай

командлалын бие бүрэлдэхүүн дундаас үнэхээр мэргэжлийн ур чадвар, байлдааны бэлэн байдлыг хангах болон тухайн оногдсон үүрэг даалгаврыг чин сэтгэлээсээ гүйцэтгэдэг байдлаараа хамгийн шилдэг нь байж, өндөр жишиг тогтоож чадсан. Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид өөрийн улсын болон Зэвсэгт хүчнийхээ үлгэр жишээ төлөөлөл болж чадсан.

Афганистаны Хойд хэсэгт бидний үүрэг гүйцэтгэлтийн нэгэн чухал хэсэг байж чадсан таны болон таны цэргүүдийг хичээл зүтгэл, оролцоог бид өндрөөр үнэлж байна. Цаашид манай хоёр улсын Зэвсэгт хүчний цэргийн хамтын ажиллагаа нь ажиллагааны газар оронд хамтран үүрэг гүйцэтгэж байсантай адил хэмжээнд маш ойр дотно, үнэ цэнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэн гэдэгт итгэлтэй байна.

Таныг хүндэтгэсэн Командлагч, Бригадын генерал АНЦГАР МАЭЙР



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 160.344 +1,243	ЭДГЭРСЭН 158.505 +2100	НАС БАРСАН 796 +7
------------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4049 +73	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 251 +14	ЭДГЭРСЭН 3722 +24
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД
Тохиолдол Нийт: 196,624,560
Эдгэрсэн Нийт: 178,072,216
Нас барсан Нийт: 4,202,565

ДЕЛЬТА ХУВИЛБАР
АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрх, нус гоожих
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавиурх, идэрх

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРЭЙ.

СПОРТ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

ТОКИО 2020: ӨНӨӨДӨР “АЛДАР”-ЫН О.ГҮНДЭГМАА БУУДАЖ, О.МӨНХЦЭЦЭГ, Л.ОТГОНБААТАР НАР БАРИЛДАНА



Токио-2020” Зуны олимпын XXXII наадмын 7 дахь өдөр буюу өнөөдөр Монголын баг тамирчдаас буудлага, жүдо бөхийн төрөлд нийт 4 тамирчин онч мэргэ, хүч, ур чадвараа сорино. Буудлагын спорт гар бууны 25 метрийн дасгалд Моголын 2 тамирчин өрсөлдөнө. Тодруулбал, Улаанбаатар хотын цагаар 08 цагаас 7 дахь олимпын наадамдаа

онч мэргэнээ сорьж буй “Алдар” спорт хорооны тамирчин, Хөдөлмөрийн баатар, олимпын мөнгөн медальт, дэд хурандаа, О.Гүндэгмаа, залуу тамирчин ОУХМ Ц.Анударийн хамт өрсөлдөнө. Өнөөдөр медалийн эзэд тодрохгүй бөгөөд эхний тогтоол 30 сумаа буудах юм. Харин маргааш буюу 30-нд спорт гар бууны медалийн эзэд тодорхой болох юм байна.

Токиогийн олимпын жүдо бөхийн тэмцээн 10 цагаас эхлэх бөгөөд Монголын баг тамирчдаас эрэгтэй -100 кг-д Л.Отгонбаатар, эмэгтэйчүүдийн -78 кг-д О.Мөнхцэцэг нар барилдана. ОУХМ Л.Отгонбаатар эхний даваанд Эстонийн Григори Минаскинтай, О.Мөнхцэцэг Израилийн Инбар Ланиртай барилдана. Тус2жингийн медалийн төлөөх барилдаан Улаанбаатарын цагаар 16:00 цагт эхэлнэ.

ОЛИМПЫН НААДАМ БОЛЖ БУЙ ТОКИОГ ДАЛАЙН ХҮЧТЭЙ ШУУРГА ЧИГЛЭН ОЙРТОЖ БАЙНА



Япон улсыг далайн хүчтэй шуурга чиглэн ойртож байгаа талаар NHK агентлаг дамжууллаа. Тодруулбал, тус улсын зүүн хэсэгт эргийн бүсийг чиглэн ойртож байгаа аж. Цаг уурын албаныхан далайн хүчтэй шуурганы хамтаар хүчтэй

хар салхи, их хэмжээний аадар бороо болон далайн өндөр давлагаа эргийн бүсийг дайрах болно хэмээн анхааруулсан байна. Мөн далайн хүчтэй шуурганы агаарын даралт төв хэсэгтээ 992 гектопаскаль байгаа бол

салхины дээд хурд нь 108 км цаг хүртэл ширүүснэ гэжээ. Японы баруун-хойд зүгийг чиглэн ойртож байгаа далайн хүчтэй шуурганы хүч өчигдрөөс улам нэмэгдэж болзошгүй хэмээн анхааруулжээ. **Эх сурвалж: NHK**

ХӨГЖИЛ ДЭВШИЛ ТАНЫ ГАРТ

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ГҮЙЦЭТГЭХ ҮЕДЭЭ БИЕ ДААН ӨӨРИЙГӨӨ ХӨГЖҮҮЛЭХ НЬ



Лүргэлжлэл нь №100/ Зорилгоо амжилттай биелүүлэхэд танд тус болж болох нэгэн зүйл:

Хамгийн түрүүнд та ажиллагааны бэлтгэлд гарах үедээ ажиллагааны зорилгуудаа тодорхойлоорой. Гэхдээ тэдгээр зорилгууд тань ажиллагааны бэлтгэлээс буух үед мөн ажиллагааны газар

оронд ирсэн эхний хэд хоногт, ингээд үндсэндээ 2 удаа багахан өөрчлөгдөж болох ба үүний дараа та зорилгоо хэрхэн төлөвлөгөө болгон буулгах вэ гэдгээ олж мэднэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл албан тушаал, орчин нөхцөл, гүйцэтгэх үүрэг болон хувийн цагаа тооцоолж мэдсэний үндсэн дээр өөрт төгс тохирох төлөвлөгөөг олж чадна гэсэн үг. Харин түүнээс хойш

ажиллагаа дуусах хүртэл тэрхүү зорилгуудаа тууштай байж өдөр бүрийн үйлдлээ тухайн зорилготойгоо уялдуулснаар та өөрчлөлтийг хийж амжилтын эзэн болох боломжтой.

Та бүхний энхийг сахиулах ариун үйлс тань гэгээн байж хийж бүтээх хүсэл мөрөөдөл тань хязгааргүй байх болтугай.

Сургагч ахлагч Ц.БАТБОЛД

ЦАГ ҮЕ

ДЕЛЬТА ВИРУСИЙН ТАРХАХ ЧАДВАР НЬ АНХНЫ ХУВИЛБАРААСАА 40-80 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ



Засгийн газрын ээлжит хуралдаан өчигдөр боллоо. Ерөнхий сайдын Хөвлөлийн төлөөлөгч Ч.Болортуяа вакцины асуудлаар мэдээлэл өгсөн юм. Тэрбээр “Монгол улсын нийт хүн амын 60 хувь нь вакцины бүрэн тундаа хамрагдаад буй. Мөн 12-17 насны хүүхдүүдээ дархлаажуулалтад хамруулж байгаа. Хүүхдүүдийг бүрэн вакцинжуулснаар хүн амын 70 орчим хувьд хүрэх тооцоолол гарч байна. 2021 оны есдүгээр сарын 1 гэхэд хүн амынхаа

60 хувийг вакцинд хамруулж амжихгүй бол халдварын тохиолдол нэг сая орчимд хүрч болзошгүй гэх тооцооллыг УОК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлөөс гаргаж байсан. Вакцинжуулснаар 180-200 мянга орчим хүн өвчлөх магадлалтай байгааг эрдэмтдийн зөвлөл хэлж байсан. Гэхдээ энэ нь дельта хувилбарын нөлөөг тусгаагүйгээр гаргасан тооцоо юм. Хэдийгээр Монгол Улс хүн амынхаа 60 хувийг вакцинжуулж, бүрэн тунд

хамрагдуулсан ч тайвшрах цаг болоогүй байгааг гэдгийг ЭМЯ-аас анхааруулж байна.

Монгол Улсад коронавирусын мутацлагдсан вирус хувилбар буюу дельта хувилбар бүртгэгдсэн тухай танилцуулсан. Өөрөөр хэлбэл, дэлхийн 124 улсад тархаад буй дельта хувилбарын вирус нь маш өндөр хурдаар өвчлөлийн хүндрэл их байдаг. Дельта вирусийн тархах чадвар нь анхны хувилбараасаа 40-80 хувиар нэмэгдсэн гэв.

ЛААРЫН ЛӨГӨӨ

ТОКИО 2020

УРИАЛГА

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ахлагч, Үндэсний шигшээ багийн тамирчин, хөнгөн атлетикийн марафон гүйлтийн олон улсын хэмжээний мастер Цэвэрравдангийн Бямбажав Японы Кюшюу аймгийн Ойтад 2020 оны хоёрдугаар сарын 2-нд болсон 64 дэх удаагийн уламжлалт “Бепу-Ойта” олон улсын марафонд хурд хрчээ сорин уралдаж, 2 цаг 09 минут 03 секундны амжилтаар V байр эзлэн “МОНШО-2020” зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ аваад байгаа билээ.

Ахлах ахлагч Ц.Бямбажав цэргийн хрний тэсвэр хатуужил, бие бийдрин өндөр бэлтгэлтэй, хурд хрчийг харуулж, эх орон, Зэвсэгт хрчин, Агаарын цэргийн алдар хрндийг тив, дэлхийд цуурайтуулах зорилго тэмрлэлтэйгээр бэлтгэл сургуулилтаа амжилттай базааж, ирэх сарын 2-ны өдөр эх орноосоо мордох гэж байна.

Цаймд ахлах ахлагч Ц.Бямбажавыг “МОНШО-2020” зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцоход шаардлагатай санхрржилтийг нь бррдррлэх хррээнд “Сэтгэлийн дэмжлэг” хандив өртөхийг Зэвсэгт хрчний Агаарын цэргийн нийт бие бррэлдэхррндээ уриалж байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДАГЧ ХОШУУЧ ГЕНЕРАЛ О.ЭНХБАЯР

Улаанбаатар хот